

## Хийсэн ажлын товч тайлан мэдээ

2013 оны 2 сарын 20 ны өдөр

Улаанбаатар хот

2012 оны 12 сарын 20-нд ажил хүлээн авсанаас хойш дараах ажлыг хийж гүйцэтгэлээ. Энэ хугацаанд ажил, хүлээн авах, байгууллагыг эмхлэн цэгцлэн, хэвийн үйл ажиллагаанд оруулах асуудалд голлон анхаарлаа. Энд нэлээн их цаг зарцуулсан (Хамгийн наад зах нь бүтэн жилийн тоос шороог цэвэрлэх гэдэг амаргүй- дургүй, уур хоёрыг зэрэг хүргэсэн ) ажил байлаа.

Нэг.Байгууллагын үйл ажиллагааны талаар:

1. Дэлхийн банкны төсөл 12 сард дуусах байсан (семинар зохион байгуулах, гарын авлага гаргах, төслийн үйл ажиллагааны тайлан гаргах зэрэг ажил хийгдээгүй) иймд төслийг үргэлжлүүлэн дуусгах эсхүл бүр зогсоох талаар ДБ-ны хүмүүстэй 3 удаа уулзалт хийж, холбогдох санал солилцсоны үндсэн дээр төслийн бид үргэлжлүүлэн хийж 3 сарын сүүлээр дуусгахаар тохиролцох шатандаа явж байна.
2. Цаашид хамтран ажиллах талаар дараах хүмүүстэй уулзалт хийлээ. Үүнд:
  - БОНХЯ-ны Сайд С. Оюунтай уулзан цаашид хамтран ажиллах санамж бичиг байгуулахаар бэлтгэж байна.
  - Ерөнхийлөгчийн Иргэний ниймийн зөвлөх Сосормаатай албан ёсоор уулзалт хийж, цаашид хамтын ажиллагаагаа өрнүүлэхээр боллоо.
  - Азийн сангийн Байгаль орчны захирал Болормаатай уулзсан. (“Хариуцлагатай уул уурхайн зарчмыг хэрэгжүүлэх нь” сэдвээр иргэний ниймийн байгууллагын төв, орон нутгийн төлөөлөл оролцсон сургалт семинар зохион байгуулах төсөл авсан )
  - БОНХЯ-ны Сайдын зөвлөх, байгаль хамгаалах сангийн ерөнхийлөгч Ш. Пүрэвсүрэнгтэй уулан бидний ажлыг дэмжин хамтран ажиллахаар болсон
  - Санхүүгийн зохицуулах хорооны төслийн ажилтан Ганбаяр зэрэг хүмүүстэй уулзалт хийлээ.
3. Хариуцлагатай уул уурхайн хөгжүүлэх чиглэлээр энэ онд хийх ажлын талаар хэд хэдэн хэвлэл мэдээллийн байгууллагаар, өөрийн байгууллагын цаашдын ажлын талаар таниулга, сурталчилгаа хийлээ. Үүнд:
  - Өвөрхангай ТВ болон ЕТВ Гүйцэтгэх захирал Баярмаа ярилцлага өгсөн.
  - Зууны мэдээ сонинд Л.Долормаа ярилцлага өглөө.
4. Байгаль орчны салбар дахь иргэдийн оролцооны эрх зүйн орчны институт дугуй ширээний ярилцлагад оролцон пресентац тавьсан
5. Ашигт малтмалын шинэ хуульд санал боловсруулах иргэний нийгмийн байгууллагын хэсэгт орж ажилласан.

6. “Ашигт малтмалын шинэ хууль уул уурхайг хариуцлагатай болгож чадах уу” сэдвээр хэлэлцүүлэгийг Ерөнхийлөгчийн Иргэний танхимд зохион байгуулахаар Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга П.Цагаанд бичиг төлөвлөн хүргүүлээд байна.

Хариуцлагатай уул уурхайн 8 зарчим тус бүрийн хэрэгжилт хуульд хэрхэн туссан, хууль хэрэгжүүлэх явцад эдгээр нь хэрэгжих боломж байгаа эсэх талаар хуульд дүн шинжилгээ хийж дүгнэлт гарган үүнийг хэлэлцүүлнэ. Дүн шинжилгээг зарчим болон түүнийг дүгнэх үзүүлэлтийг боловсруулахад оролцсон хүмүүс болон манай ТУЗ-ийн гишүүд хийнэ.

7. Хамтран ажиллах талаар Уул уурхайн яамны сайд Ганхуягтай уулзах хүсэлтийг бичгээр тавьж яаманд хүргүүлээд байна.

Хоёр. Байгууллагын дотоод ажлын талаар:

1. Шинэ байранд нүүж орсон. (хуучин байсан газар нь хажуудаа 3-4 залуучууд ажилладаг байрны коридор болох өрөөнд манайх байрлаж байсан бөгөөд тэдгээр эрэгтэй хүмүүсийн 00 өрөө нь шууд манай өрөөгөөр дамждаг, тэд хоолоо манай өрөөнд хийдэг, манай ширээ сандалуудыг тэд ашигладаг, ширээ, хувилах машин зэрэг бүх хэрэгслэлийг тэд чөлөөтэй хэрэглэдэг ийм газар байсан юм. Тэгээд байрны түрээсэн дээр халаалт, гэрлийн мөнгө нэмж төлдөг.)
2. Тамга тэмдэгийн өөрчлөлт хийсэн (санхүүгийн баримт бичиг будлиантай байсан нэдлээд зөрчил дутагдал гарсаныг та бүхэн мэдэж байгаа иймд бид үйл ажиллагаагаа шинээр эхлэх нь зүйтэй гэсэн хуулийн хүмүүсийн саналын дагуу тэмдэгээ өөрчилсөн.

Гурав. Санхүүгийн талаар:

1. ДБ-ны шугамаар болсон сургалт семинарт Австралиас ирсэн багшийн замын зардал болох \$6.128.68 USA төлсөн. ( үүнийг өнөө болтол төлөөгүй, ДБ нэхсэн тул төлсөн болно.)
2. Датаком болон утас, интернетийн мөнгийг тус бүр сүүлийн 3 сар төлөөгүй байсныг төлсөн болно.